

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2017 оны.....дугаар  
сарын.....-ны өдөр

Дугаар....

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1."Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийг боловсруулах, мэдээлэл өгөх, солилцох, барьцааны эрхийн мэдэгдлийг бүртгэж дугаар олгох, нийтэд нээлттэй байх болон статистикийн зориулалттай мэдээллийн төрлийг тогтоох журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга /Р.Содхүү/-д даалгасугай.

3.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Э.Энхтуяа/-д даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

## **ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ БОЛОН ЭДИЙН БУС ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ МЭДЭГДЛИЙГ БҮРТГЭХ ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийг боловсруулах, мэдээлэл өгөх, солилцох, барьцааны эрхийн мэдэгдлийг бүртгэж дугаар олгох, нийтэд нээлттэй байх болон статистикийн зориулалттай мэдээллийн төрлийг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх нь хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрхийн талаар олон нийтэд мэдээлж, ил тод болгох, тухайн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалан үүргийн гүйцэтгэлийг хангах сонирхол бүхий гуравдагч этгээдэд анхааруулга /мэдээлэл/ өгөх зорилготой болно.

1.3.Барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлснээр үүрэг гүйцэтгүүлэгч тухайн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хувьд үүссэн барьцааны эрхээ хэрэгжүүлэх дарааллаа Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан журмын дагуу тогтоолгоно.

1.4.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сан /цаашид “цахим мэдээллийн сан” гэх/-ийн үйл ажиллагааг зохицуулахад Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, бусад хууль тогтоомж, энэхүү журмыг баримтална.

1.5.Улсын бүртгэлийн байгууллага нь Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 34.1, 35.2, 35.3, 37.2 дахь хэсэгт зааснаас гадна цахим мэдээллийн санд нэвтрэх эрх олгох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### **Хоёр.Цахим мэдээллийн санг бүрдүүлэх, удирдах, ажиллуулах**

2.1.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 35.1 дэх хэсэгт заасан цахим мэдээллийн санг иргэн, хуулийн этгээдийн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн цахим бүртгэлийг үндэслэн үүсгэнэ.

2.2.*Бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “бүртгэлийн байгууллага” гэх/ нь цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, түүний тасралтгүй үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй байна.*

2.3.Барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэхтэй холбоотой аливаа асуултад хариулах, цахим бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэн, хуулийн этгээдэд тусламж үзүүлэх утсыг бүртгэлийн байгууллага ажлын цагаар ажиллуулж уг утасны дугаарыг өөрийн цахим хуудсанд байршуулна.

2.4.Барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд долоо хоногийн 24 цагийн турш бүртгүүлэх, хайлт хийх боломжтой байна. Цахим мэдээллийн сангийн үйл ажиллагаа түр зогсох тохиолдолд үйл ажиллагаа хэвийн ажиллаж эхлэх хугацаа, шалтгааны талаарх мэдээллийг бүртгэлийн цахим хуудсанд байршуулна.

### **Гурав.Барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх**

3.1.Барьцааны мэдэгдлийг бүртгэлийн байгууллагын эрхлэн хөтлөх цахим хуудсаар дамжуулан цахим мэдээллийн санд бүртгүүлнэ.

3.2.**Барьцааны мэдэгдэл** гэж хуульд өөрөөр заагаагүй бол хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хувьд үүссэн барьцааны эрхийн талаарх анхны мэдэгдэл, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай мэдэгдэл, мэдэгдлийн бүртгэлийг сунгах болон цуцлах мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, барьцаалагч барьцааны шаардлагаа хангах ажиллагаа эхлүүлсэн тухай тэмдэглэгээ зэргийг ойлгоно.

### **Дөрөв.Хуульд заасны дагуу үүссэн барьцааны мэдэгдлийг бүртгүүлэх**

4.1. Хуульд зааснаар үүссэн барьцааны мэдэгдлийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 40.4 дэх хэсэгт заасан байгууллага, албан тушаалтан буюу дампуурлын тухай хууль тогтоомжид заасны дагуу үүсэх барьцааг шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч, шүүхийн шийдвэрээр үүсэх барьцааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, татварын хууль тогтоомжид заасны дагуу үүсэх барьцааг татварын байгууллага барьцаалуулагчийн зөвшөөрөлгүйгээр цахим мэдээллийн санд оруулна.

4.2.Энэ журмын 4.1-д заасан албан тушаалтан нь цахим мэдээллийн санд бүртгэлийн байгууллагаас авсан эрхээр нэвтрэх бөгөөд барьцааны мэдэгдэлд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан зүйлийг тусгана.

4.3.Хуульд заасны дагуу үүссэн барьцааны мэдэгдэлд “хуульд заасны дагуу үүссэн барьцаа” гэсэн тэмдэглэгээ хийнэ.

4.4.Хуульд заасны дагуу үүссэн барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд оруулах эрх бүхий байгууллага нь цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг улсын бүртгэлийн байгууллагад албан бичгээр хандаж авна.

### **Тав.Гэрээний үндсэн дээр үүссэн барьцааны мэдэгдлийг бүртгүүлэх**

5.1.Барьцаалагч нь дараахь шаардлагыг хангасан тохиолдолд барьцааны анхны мэдэгдлийг бүртгүүлж болно:

5.1.1.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 9.1 дэх хэсэгт зааснаар барьцааны эрх үүссэн эсхүл энэ хуулийн 40.3 дахь хэсэгт заасны дагуу талууд бичгээр харилцан тохиролцсон;

5.1.2.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 40.2 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг авсан;

5.1.3.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 40<sup>1</sup>.1-д заасан улсын тэмдэгтийн хураамж төлсөн;

5.1.4.Цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг улсын бүртгэлийн байгууллагаас авсан.

5.2.Барьцаалагч, эсхүл түүний төлөөлөгч нь *барьцааны мэдэгдэл бүртгүүлэх эрхийн дагуу* Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан мэдээллийг тусгасан барьцааны мэдэгдлийг мөн хуулийн 40.1 дэх хэсэгт заасны дагуу бүртгүүлнэ.

5.3.Иргэн, хуулийн этгээд нь барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх эрхийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 40<sup>1</sup>.1 дэх хэсэгт заасан төлбөрийг төлж авна. /бүрдүүлэх баримт бичгийг тусгах/

5.4.Барьцааны мэдэгдэл цахим мэдээллийн санд оруулах, цахим мэдээллийн сангаас лавлагаа авах эрх авсан иргэн, хуулийн этгээд нь өөрийн нэрийн өмнөөс системд нэвтрэх эрхийг нэг болон хэд хэдэн этгээдэд олгосон бол эрхийн дагуу системд холбогдож байгаа этгээдийн үйлдэлд хяналт тавих, системийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

5.5.Хуульд өөрөөр заагаагүй бол барьцааны мэдэгдлийн холбогдох мэдээллүүдийг оруулж амжилттай хадгалснаар цахим мэдээллийн санд барьцааны мэдэгдлийн бүртгэл үүсэж уг цаг мөчөөс эхлэн барьцааны эрхийг бүртгэлээр баталгаажсанд тооцно. Хуулийн 4 дүгээр зүйлийн 41.1-ийн дагуу өөрчлөх

5.6.Барьцааны мэдэгдлийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хугацаа сунгах, цуцлахдаа барьцааны мэдэгдлийг бүртгэсэн анхны бүртгэлийн дугаарыг ашиглан цахим санд барьцааны мэдэгдлийг бүртгүүлнэ.

### **Зургаа.Барьцааны мэдэгдлийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах**

6.1.Барьцааны мэдэгдлийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 42.2, энэ журмын 5.3-д заасан нөхцөл шаардлагыг хангасан байна. *Энэ барьцаалагч нь анхны бүртгэл дээр бүртгэгдсэн эсхүл уг бүртгэл нэмэлт, өөрчлөлт оруулах бүртгэлд туссан барьцаалагч байна.*

6.2.Барьцааны мэдэгдлийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах мэдэгдэлд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 42.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгана.

6.3.Нэмэлт, өөрчлөлт оруулах мэдэгдлээр анхны бүртгэлийн хүчинтэй байдал, дуусгавар болох хугацаанд нөлөөлөхгүйгээр агуулгыг өөрчилнө.

6.4.Барьцааны мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах мэдэгдэл нь хамгийн багадаа нэг барьцаалагч, нэг барьцаалуулагч, нэг барьцааны зүйлийн дүрслэлийг зайлшгүй агуулсан байна.

### **Долоо.Барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хугацааг сунгах**

7.1.Барьцааны мэдэгдлийн бүртгэлийг сунгахдаа Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 43.1, энэ журмын 5.3-д заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

7.2.Барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хугацааг сунгах мэдэгдэлд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 43.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгаж, энэ хуулийн 43.2, 43.3 дахь хэсэгт заасны дагуу сунгах мэдэгдлийг

анхны бүртгэлийн хүчин төгөлдөр хугацаа дуусахаас өмнө зургаан сарын дотор бүртгүүлнэ. Барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хүчинтэй байх хугацааг гурван жилээр сунгаж болно.

### **Найм.Барьцааны мэдэгдлийн бүртгэлийг цуцлах**

8.1.Барьцааны мэдэгдлийн бүртгэлийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар цуцлана.

Х.Х.Анхны мэдэгдэл болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай мэдэгдэлд нэгээс илүү барьцаалагч бүртгэгдсэн байвал цуцлах мэдэгдэл гагцхүү цуцлах зөвшөөрөл өгсөн тухайн барьцаалагчийн хувьд л хүчинтэй байна.

8.2.Барьцаалуулагч дараахь үндэслэлээр шүүхийн шийдвэр гаргуулсны үндсэн дээр тухайн барьцааны мэдэгдлийг цуцлах хүсэлтийг бүртгэлийн байгууллагад гаргаж болно:

8.2.1.барьцаалагчийн зүгээс тухайн барьцааны үүрэг дуусгавар болсон байхад цуцлах мэдэгдэл оруулаагүй;

8.2.2.барьцаалуулагчийн зүгээс тухайн барьцааны мэдэгдэл үнэн зөв хүчин төгөлдөр биш гэдгийг нотолсон.

8.3.Барьцаалуулагч нь бүртгэлийн мэдэгдлийг цуцлуулах тухай хүсэлтийн хамт нотариатаар гэрчлэгдсэн шүүхийн шийдвэрийн хуулбарыг бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ. Бүртгэлийн ажилтан цуцлах мэдэгдлийг мэдээллийн санд оруулж, цуцлах мэдээлэлд шүүхийн шийдвэрийг PDF өргөтгөлөөр хөрвүүлж хавсаргана.

8.4.Цуцлах мэдэгдлийг оруулснаар системээс тухайн барьцааны мэдэгдэл алга болохгүй.

8.5.Цуцлах мэдэгдлийг тухайн барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хугацаа дуусахаас өмнө оруулна.

### **Ес.Барьцааны мэдэгдлийн бүртгэлд нэмэлт тайлбар оруулах, барьцааны эрх хэрэгжүүлэх мэдэгдлийг бүртгэлд тэмдэглүүлэх, хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн барьцааг бүртгүүлэх**

9.1.Барьцааны мэдэгдлийн бүртгэлтэй бүхэлд нь болон хэсэгчлэн санал нийлэхгүй байгаа, тухайн мэдэгдэлд нэр дурдагдсан барьцаалуулагч Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу мэдэгдэлд тайлбар оруулж болно.

9.2.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 50.2 дахь хэсэгт зааснаар барьцаа нь бүртгэлээр баталгаажсан барьцаа бол барьцаалагч барьцааны шаардлагаа хангах ажиллагаа эхлүүлсэн тухай цахим мэдээллийн санд тэмдэглүүлнэ.

9.3.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн барьцааг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нийцүүлэн цахим мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулж болно.

### **Арав. Мэдээлэл оруулах, хянах, илгээх, татгалзах, хүлээн авах**

10.1.Цахим мэдээллийн санд бүртгэх программ нь Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 39.1, 42.1, 43.1, 44.1 дэх хэсэгт заасан мэдээллийг оруулсан эсэхийг шалгана.

10.2.Энэ журмын 10.1-д заасан шаардлагын дагуу мэдээлэл оруулаагүй бол бүртгэх программ тэр даруй мэдээлэл оруулж байгаа хэрэглэгчид анхааруулж дутуу орхисон талбарыг бөглөж мэдээллийг бүрэн оруулахыг сануулна.

10.3.Хэрэглэгч холбогдох бүх мэдээллийг оруулсны дараа бүртгэлийн программ нь оруулсан мэдээллийг нэгтгэн харуулж хянах боломж олгоно. Хэрэглэгч мэдээллүүдээ ямар нэг алдаагүй оруулсан эсэхээ бүртгэлийн цахим мэдээллийн санруу илгээхээс өмнө хянаж засах боломжийг олгоно.

10.4.Хэрэглэгч энэ журамд заасан шаардлага хангасан мэдээллийг оруулсан бол бүртгэлийн систем мэдэгдлийн өгөгдлийг хүлээн зөвшөөрч мэдэгдэл нь цахим санд бүртгэгдсэн талаарх бүртгэлийн дугаарыг олгоно. Мэдээллийн санд мэдэгдлийг бүртгүүлснээр өгөгдлийг дахин засах боломжгүй. Мэдэгдэл бүртгэгдмэгц тэр даруй хайлтын үр дүнд гарч ирэх боломжтой болно.

10.5.Барьцаалагч, барьцаалуулагч талууд, тэдгээрийн төлөөлөл нь Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 45.3 дахь хэсэгт заасны дагуу цахим мэдээллийн санд үнэн зөв мэдээлэл оруулах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ зөрчсөнөөс бусдад учирсан хохирлыг мэдээлэл оруулсан буруутай этгээд нөхөн төлнө.

*10.6.Бүртгэлийн байгууллага нь цахим санд оруулж буй барьцааны мэдэгдлийн мэдээллийн үнэн зөв эсэхэд аливаа хяналт шалгалт хийхгүй.*

10.7.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан татгалзах үндэслэл бүрдсэн тохиолдолд бүртгэх программ барьцааны мэдэгдлийг бүртгэхээс татгалзана.

*10.8.Мэдээллийн сангийн ашиглалтын талаар хийсэн бүх үйлдлүүд, хандалт зэрэг нь системд бүртгэгдэнэ.*

10.9.Цахим бүртгэл мэдэгдлийг хүлээн зөвшөөрсөн үед дараахь бүрдүүлбэр бүхий хуудсыг олгоно:

10.9.1.Барьцаалагчийн оруулсан мэдээлэл;

10.9.2.Бүртгүүлсэн өдөр, цаг, минут;

10.9.3.Энэ журмын 12.1-д заасны дагуу олгосон мэдэгдлийн бүртгэлийн дугаар.

### **Арван нэг.Барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгэж дугаар олгох**

11.1.Анхны мэдэгдэл, нэмэлт өөрчлөлт оруулах тухай мэдэгдэл, хугацаа сунгах тухай мэдэгдэл, цуцлах тухай мэдэгдлийн бүртгэл тус бүрт цахим мэдээллийн сангаас дахин давтагдахгүй дугаарыг автоматаар олгоно. Дугаар бүр "0"-ээр эхэлсэн тооноос бүрдэнэ. /тайлбар, тэмдэглэгээ хийхэд дугаар олгох эсэх/

11.2.Барьцааны анхны мэдэгдэл бүрт бүртгэлийн дугаарын бүрдэл хэсэг болж түүний төгсгөлд бичигдэх нэмэлт 2 оронтой тоог бүртгэлийн системээс өгч байна. Үл

давхцах тоо болох нэмэлт орон тус бүрийг математикийн тооцооллын дагуу гаргаж ирэх бөгөөд энэ нь анхны мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, анхны мэдэгдлийн хугацаа сунгах, анхны мэдэгдлийг цуцлах мэдэгдэлд оруулахад шууд баталгаажуулах дугаар болж ашиглагдана.

11.3.Бүртгэлийн систем нь барьцааны анхны мэдэгдлийн дугаартай түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, хугацаа сунгасан, цуцалсан бүх мэдэгдлийг холбосон байна. Анхны болон түүнтэй холбоотой бүх мэдэгдлийг бүртгэлийн өдөр, цаг, минутыг цахим мэдээллийн сан харуулах боломжтой байна.

11.4.Бүртгэлийн системд мэдэгдлийн хугацаа дуусгавар болох хүртэл олон нийт хяналт тавих боломжтой байлгана.

11.5.Бүртгүүлсэн мэдэгдэл бүрийн талаарх мэдээллийг сунгах мэдэгдэл орсноос бусад тохиолдолд бүртгүүлснээс хойш 3 жилийн хугацаанд хадгалж хайлт хийн үзэх боломжтой байлгана.

11.6.Хугацаа дууссан мэдэгдлийн бүртгэл дуусгавар болсноос хойш 5 жилийн турш хайлт хийх болон үзэх боломжгүй байдлаар хадгалагдана. Ийм мэдэгдлийг хуульд заасан үндэслэлээр Бүртгэлийн эрх бүхий байгууллага сэргээх буюу ашиглаж болно.

### **Арванхоёр. Цахим мэдээллийн санд хайлт хийх, нийтэд нээлттэй байх**

12.1.Дурын этгээд бүртгэгдсэн барьцааны мэдэгдлийг бүртгэлийн байгууллагын цахим хуудаст нэвтрэх зөвшөөрөл, нууц үг, төлбөргүйгээр хайлт хийх, үзэх боломжтой байна.

12.2.Хэрэглэгч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 40<sup>1</sup>.1.3-т заасан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлж, эрх бүхий бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гарган цахим хэлбэрээр лавлагаа авах эрхтэй.

12.3.Барьцааны мэдэгдлийн талаар хайлт хийхэд тухайн цаг үед хүчин төгөлдөр байгаа холбогдох барьцааны мэдэгдлийн бүх бүртгэл гарч ирнэ.

12.4. Дурын этгээд дараах аль нэг түлхүүрийг ашиглан барьцааны мэдэгдлийн талаар хайлт хийх боломжтой:

12.4.1. Анхны мэдэгдлийн бүртгэлийн дугаар;

12.4.2. Барьцаалуулагчийн дараахь мэдээллээр:

12.4.2.а.Монгол Улсын иргэн бол регистрийн дугаар;

12.4.2.б.гадаадын иргэн, *харьяалалгүй хүн* бол паспорт буюу түүнтэй адилтгах баримт бичгийн дугаар;

12.4.2.в.хуулийн этгээд бол улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, нэр.

#### **12.4.3.сериал дугаар бүхий эд хөрөнгө бол сериал дугаар.**

12.5.Цахим мэдээллийн сангийн нийтэд нээлттэй хайлтын үр дүнд барьцаалуулагч иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол байгууллагын нэр, барьцааны бүртгүүлсэн огноо, төлөв гарна.

12.6.Энэ журмын 13.2-т заасан лавлагаанд барьцаалуулагчийн нэр /иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр/, регистрийн дугаар, барьцааны огноо, барьцааны дүрслэл, төлөв гэсэн мэдээлэл гарна.

### **Арван гурав.Төлбөр төлөх үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ**

13.1.Барьцааны мэдэгдлийн анхны бүртгэл, анхны бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, сунгах болон цахим мэдээллийн сангаас лавлагаа олгоход Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 40<sup>1</sup>.1-д заасан заасан төлбөр авна.

13.2.Барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хугацааг цуцлах мэдэгдлийг бүртгүүлэх болон хуулийн дагуу үүссэн барьцааны мэдэгдлийг бүртгүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулахад хэрэглэгчээс төлбөр авахгүй.

13.3.Хэрэглэгчид дараахь байдлаар үйлчилгээний төлбөрийг төлөх боломжтой:

13.3.1.Банкны төлбөрийн картаар төлбөр хийх

13.3.2. Банкаар дамжуулан төлбөр хийх

13.3.2.а.бүртгэлийн байгууллагаас аль нэг банктэй гэрээ байгуулан бүртгэлийн байгууллагын дансыг нээх ба дансны мэдээллийг бүртгэлийн байгууллагын цахим мэдээллийн сангийн веб хуудсанд байршуулна. Банк хэрэглэгчээс төлбөрийг хүлээн авч, баталгаажуулалт хийх дугаар бүхий төлбөрийн баримт гаргах ба төлбөрийн нарийвчилсан мэдээллийг баримтын дугаарын хамт интернетээр мэдээллийн санд илгээнэ.

13.3.2.б.хэрэглэгч тухайн сард хийсэн гүйлгээнийхээ төлбөрийн нэхэмжлэх дээр үндэслэн бүртгэлийн байгууллагын энэ журмын 13.3.2.а-д заасан данс руу зохих төлбөрийг хийж болно. Ингэхдээ төлбөрийн баримтын тусгай дугаараа ашиглах ба энэ дугаараар систем тухайн харилцагчийн хувийн мэдээлэлд төлбөр төлсөн талаарх бичилт хийнэ.

13.3.2.в.хэрэглэгч үйлчилгээ авахын тулд өөрийн бичиг баримтаа шалгуулан бүртгэлийн байгууллагын банкин дах дансанд зохих төлбөрийг тушаан тусгай дугаар банкнаас авч болно. Уг дугаараа ашиглан цахим мэдээллийн сангийн веб хуудас руу нэвтэрнэ. Бүртгэлийн програм тухайн хэрэглэгчийн төлсөн төлбөрийн хүрээнд үйлчилгээ авах боломжоор хангана. Хэрэглэгчийн төлбөр төлж авсан тусгай дугаар 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. *(энэ хугацаа харьцангуй богино байх ба ашиглаагүй мөнгөө буцаан авах боломжийг тусгах нь зөв)*

13.3.3.Банк хоорондын шилжүүлэг

13.3.3.а.харилцагч тухайн сард хийсэн гүйлгээнийхээ төлбөрийн нэхэмжлэх дээр үндэслэн бүртгэлийн байгууллагын банкин дахь данс руу өөрийн банкны данснаас зохих төлбөрийг хийж болно. Ингэхдээ өөрийн харилцагчийн дугаараа оруулсан байна. Төлбөр төлсөн тухай мэдээллийг тухайн харилцагчийн бүртгэлийн байгууллагын систем дэх хувийн мэдээлэл дээр байнга тэмдэглэж байна.

### **Арвандөрөв.Статистикийн зориулалттай мэдээлэл**

14.1.Улсын бүртгэлийн байгууллагаас статистик мэдээг сар, улирал, жилээр гаргаж, Үндэсний статистикийн хороо болон Төв банк /Монголбанк/-нд хүргүүлнэ.

14.2.Гэрээгээр үүссэн барьцааны мэдэгдлийн мэдээллийг статистикийн зориулалтаар ашиглах зорилгоор нэмэлт мэдээлэл шаардаж болно.

14.3.Статистик мэдээллийн нэгдсэн дүн нийтэд нээлттэй байна.

14.4.Энэ журмын 15.1-д заасан статистикийн мэдээг дараахь үзүүлэлтээр гаргана:

14.4.1.хуульд заасны дагуу болон гэрээний дагуу үүссэн барьцааны мэдэгдэл тус бүрийн тоо;

14.4.2.бүртгэгдсэн барьцааны анхны, нэмэлт өөрчлөлт орсон, хугацаа сунгасан, цуцалсан мэдэгдлийн тоо;

14.4.3.барьцаалагч, барьцаалуулагчийн төрөл /иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээд бол төрөл/

14.4.4.үүрэг гүйцэтгэгч иргэн бол хүйс;

14.4.5.үүрэг гүйцэтгэгч нь хуулийн этгээд бол жижиг, дунд эсхүл томоохон аж ахуйн нэгж;

14.4.6.үүрэг гүйцэтгэгч нь шинэ эсхүл хуучин хэрэглэгч;

14.4.7.үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа явуулдаг салбар;

14.4.8.Үүргийн дүн /Барьцаагаар хангагдсан үүргийн үнийн дүн.Барьцаагаар хангагдсан үүрэг нь зээлийн шугамын гэрээнээс үүссэн болон хэлбэлзэх үүрэг бол уг үүргийн үнийн дүнгийн дээд хязгаарыг оруулна. (Жишээ нь: зээлийн шугамны хувьд зээлийн шугамын дээд хязгаарыг барьцаагаар хангагдсан үүргийн үнийн дүн гэж тооцно.)/

14.4.9.төлөв

14.4.10.барьцааны зүйлийн төрөл

14.4.11.бусад

---oooOooo---